

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН
УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ БАТЛАХ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хууль, тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсэгт тусгагдсан давхардсан агуулга бүхий хэсгийг хасах, 2.7 дахь хэсгийн аймаг, нийслэл үнэт цаас гаргах эрхтэй болж санхүүгийн шинэ хэрэгсэл ашиглаж эхэлсэн хугацааг болон зарим бондын эргэн төлөгдөх хугацааг тодорхой болгож тусгах, 4.8 дахь хэсэгт тусгагдсан Засгийн газрын дотоод үнэт цаасыг тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна гэснийг Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна гэж өөрчлөхтэй холбогдсон зарчмын санал болон төслийн үг хэллэг, нэр томьёог жигдлэх, техникийн засвар бүхий найруулгын санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж
өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН